



СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/119

Алтанбулаг

Шүлхий өвчнөөс сэргийлэх яаралтай  
дархлаажуулалтын ажлыг зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11 дүгээр заалт 66 дугаар зүйлийн 66.1 дүгээр заалт, “Мал амьтны эрүүл мэндийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.4, 9 дүгээр зүйлийн 9.3-9.8, Төсвийн тухай хууль 23 дугаар зүйлийн 23.8.16 дугаар заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дүгээр заалт, аймгийн Засаг даргын 05 дугаар сарын 11-ны өдрийн А/197 тоот захирамж, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/77 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд мал амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын ажлыг 2022 оны 10 дүгээр сарын 14-ны өдрөөс 2022 оны 10 дугаар сарын 24-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтын арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай

Комиссын дарга

Ү. Янжиндулам ( Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүдэд

Р. Үнэнбат (Санхүү албаны дарга)

Б. Биндэръяа (Мал эмнэлгийн тасгийн дарга )

М. Цэгмид (Тархварзүйч)

Э. Зориг (1 дүгээр багийн Засаг дарга)

Н. Мөнхзул ( 2 дугаар багийн Засаг дарга)

Г. Мөнхболд (3 дугаар Засаг дарга)

Л. Гантөмөр (Бумбат-Өлгий ББН малын эмч)

Р. Булгаа (Бөхлөө-Хангай ХХК малын эмч )

3. Ажлын хэсэгт ДААЛГАХ нь:

а/ Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулах үйл ажиллагаанд аж ахуй нэгж байгууллага, малчин, мал бүхий өрхийн 2021 оны жилийн эцсийн мал тооллогод хамрагдсан үхэр, гахайг бүрэн хамруулах

б/ Дархлаажуулалтын явцад мал амьтны шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулах

в/ Дархлаажуулах ажлаас малаа хоцроосон, зайлсхийсэн аж ахуй нэгж байгууллага, иргэд, хариуцлагагүй хандсан албан тушаалтанд хуулийн дагуу арга хэмжээ авч хариуцлага тооцох

г/ Дархлаажуулалтын товлосон хугацаанд мал, амьтныг бэлэн байлгаж бэхлэх, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдүүлж, малын эмчийн аюулгүй байдлыг бүрэн хангах

д/ Энэ арга хэмжээний зорилго ач холбогдол хор хохирлын талаар ухуулга сурталчилгаа зохион байгуулах

е/ Арга хэмжээг товлот хугацаанд чанартай хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тайланг гарган санхүүжилтийн материалыг бүрдүүлэн сумын Засаг даргаар батлуулж аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлсүгэй.

4. А/01 өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын хүн хүчний судалгааг 1 дүгээр хавсралтаар, шаардлагатай шатахууны зардлын тооцоог 2 дугаар хавсралтаар, дархлаажуулалтын замын маршрутыг 3 дугаар хавсралтаар, хоол хүнс, цалин тооцоо бусад зардлыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

5. Дархлаажуулалтын явцад гарах шатахуун, хоол хүнс, цалин, бусад зүйлд зарцуулагдах 5,867,300 (таван сая найман зуун жаран долоон мянга гурван зуун төгрөг)-ийг орон нутгийн хөгжлийн сангаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан (Э.Цэнд-Аюуш)-д зөвшөөрсүгэй.

6. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж, Засаг даргыг мэдээллээр хангаж ажиллахыг сумын Засаг даргын орлогч /Х. Отгонжаргал/-д үүрэг болгосугай.



Н. ОТГОНЦОГТ